



**ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ШИНЭЧЛЭЛТ**

Эмнэлгийн
тусламжийн газар

Агуулга


- Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны өнөөгийн байдал, хууль, эрх зүйн орчин
- Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны шинэчлэлт

Эрүүл мэндийн байгууллагын магадлан ИТГЭМЖЛЭЛ

Эрүүл мэндийн байгууллагын
магадлан итгэмжлэл нь тусламж
үйлчилгээний технологи, чанарт
хөндлөнгийн шинжилгээ, үнэлгээ
хийж дүгнэлт гаргах үйл ажиллагаа

Магадлан итгэмжлэл нь байгууллагыг хөгжүүлэх
хөшүүрэг, чанарын баталгаажилт

Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагууд



Онууд	Магадлан итгэмжлэгдсэн ЭМБ-уудын тоо		Нийт
	Аймаг	Нийслэл	
2012 он	119 (26,8%)	36 (23,2%)	155
2013 он	177 (76,6%)	54 (23,3%)	231
2014 он	159 (74,6%)	54 (25,4%)	213
2015 он	131 (64,2 %)	73 (35,8%)	204
2016 он	77 (60,6%)	50 (39,4%)	127

2016 оны жилийн эцэст 703 ЭМБ-ын магадлан итгэмжлэл хүчинтэй байна.

- аймаг 498, нийслэл-205

№	Аймгийн нэр	Магадлан итгэмжлэгдсэн ЭМБ-ын тоо
1.	Архангай	26
2.	Баян-Өлгий	25
3.	Баянхонгор	32
4.	Булган	24
5.	Говьсүмбэр	4
6.	Говь-Алтай	28
7.	Дорнод	13
8.	Дархан-Уул	22
9.	Дундговь	22
10.	Дорноговь	24

№	Аймгийн нэр	Магадлан итгэмжлэгдсэн ЭМБ-ын тоо
11.	Завхан	32
12.	Орхон	18
13.	Өмнөговь	22
14.	Өвөрхангай	27
15.	Сэлэнгэ	14
16.	Сүхбаатар	20
17.	Төв	34
18.	Увс	24
19.	Хэнтий	31
20.	Хөвсгөл	28
21.	Ховд	28

Нийслэлийн ЭМБ-ууд -2016 он

№	ЭМБ-ын төрөл, нэр	Магадлан итгэмжлэгдсэн ЭМБ-ын тоо
1.	ЭМЯ-ны харъяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв	11
2.	Тусгай эмнэлэг	11
4.	Хувийн хэвшлийн эмнэлэг	97

№	ЭМБ-ын төрөл, нэр	Магадлан итгэмжлэгдсэн ЭМБ- ЫН ТОО
5.	Рашаан сувилал, сувилал /Оргил, Хүүхдийн төв сувилал, Багануурын сувилал/	33
6.	Дүүргийн Нэгдсэн эмнэлэг	4
7.	Дүүргийн ЭМТ	8
8.	Өрхийн ЭМТ	39
9.	Тосгоны ЭМТ	2

Магадлан итгэмжлэгдсэн хугацаа

Онууд	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа/ ЭМБ-ын тоо					Нийт
	1 жил	2 жил	3 жил	4 жил	5 жил	
2013 он	3	36	105	72	15	231
2014 он	-	26	111	67	9	213
2015 он	17 8,3%	65 31,8%	60 29,4%	56 27,5%	6 2,9%	204
2016 он	21 16,5%	44 34,6%	28 22,1%	32 25,1%	2 1,6%	127

Хууль, эрх зүйн баримтууд

- ✓ Эрүүл мэндийн тухай /22-р зүйл/
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухайн хууль
- ✓ “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлах тухай” ЭМС-ын 2013 оны 247 дугаар тушаал / 4 хавсралт/
- ✓ “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлого батлах тухай” ЭМС-ын 2014 оны 55 дугаар тушаал /2.6/
- ✓ “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” ЭМС-ын 2014 оны 237 тоот тушаал /ЭМБ-ыг магадлан итгэмжлэх журам”

Хууль, эрх зүйн баримтууд

- ✓ “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт батлах тухай” ЭМС-ын 2014 оны 07 дугаар тушаал /6 хавсралт/
- ✓ “Батламжийн загвар шинэчлэн батлах тухай” ЭМС-ын 2013 оны 28 тоот тушаал
- ✓ “Чанарын хөтөлбөрийн загварыг батлах тухай” ЭМС-ын 2013 оны 437 тоот тушаал
- ✓ “Магадлан итгэмжлэлийн шинжээч ажиллуулах тухай” ТНБД-ын 2014 оны 155 дугаар тушаал

Хууль, эрх зүйн баримтууд

- ✓ “Үнэлгээний хуудас, аргачлал батлах тухай” ЭМСС-ын 2015 оны 363 дугаар тушаал
- ✓ “Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд хөтлөх маягт батлах тухай” ЭМСС-ын 2015 оны 499 дүгээр тушаал /маягт №1, 2/
- ✓ “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” ЭМСС-ын 2016 оны 52 дугаар тушаал /маягт №3/

Хууль, эрх зүйн баримтууд

- ✓ “Журамд өөрчлөлт оруулах тухай” 2016 оны А/197 дугаар тушаал
- ✓ Магадлан итгэмжлэлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай” ЭМС-ын 2016 оны А/161 дугаар тушаал
- ✓ Магадлан итгэмжлэлийн шинжээч сонгон шалгаруулж, томилох, чөлөөлөх журам батлах тухай” ЭМС-ын 2017 оны А/118 дугаар тушаал

Эрүүл мэндийн тухай хууль /22-р зүйл/

22.1 Эрүүл мэндийн байгууллага сайн дурын үндсэн дээр өөрийн байгууллагын үйл ажиллагааг болон хүн амд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний технологи, чанарыг үнэлүүлж, магадлан итгэмжлэл авна.

22.2 ЭМБ-ын магадлан итгэмжлэлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

22.3 Магадлан итгэмжлэх байгууллага нь эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, чанарыг орон тооны бус шинжээчдээр үнэлүүлж, дүгнэлт гаргана.

Эрүүл мэндийн тухай хууль /22-р зүйл/

22.4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх, шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах журам, магадлан шинжлэх шалгуур, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ЭМС-ын 2013 оны 247 дугаар тушаал

I. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам /2014 оны 237 тоот тушаалаар хүчингүй болсон/

II. Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн сонгон шалгаруулж, томилох, чөлөөлөх журам

III. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн ажиллах журам

IV. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг

ЭМС-ын 2014 оны 237 тоот тушаал

1.6 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч 2 ба түүнээс дээш жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан эрүүл мэндийн байгууллага магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргана.

1.7 Монгол улсад эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд заагдсан тусламж, үйлчилгээг үзүүлэх болон удаан хугацааны нөхөх эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь 1.6-д заасан хугацаанаас өмнө магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргавал зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны үе шатууд

- I. Эрүүл мэндийн байгууллага магадлан итгэмжлэлд бэлтгэх;
- II. Байгууллагын ирүүлсэн материалд дүн шинжилгээ хийх;
- III. Шинжээчдийн баг газар дээр нь үнэлгээ хийх;
- IV. Шинжээчдийн нэгдсэн дүгнэлтийг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх
- V. Эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэх эсэх шийдвэр гаргах.

Магадлан итгэмжлэлд бэлтгэх

✓ Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргахаас 12-18 сарын өмнөөс эхлэн дараах бэлтгэл ажлыг хийсэн байна.

Бэлтгэл ажлын хүрээнд:

✓ магадлан итгэмжлэлд бэлтгэх багийг зохион байгуулж, чанар сайжруулах үйл ажиллагаанд хамт олныг оролцуулах;

✓ тусламж үйлчилгээний чанарын төлөвлөгөө (чанарын хөгжлийн хөтөлбөр) батлуулж, хэрэгжүүлэх;

✓ магадлан итгэмжлэх үйл ажиллагаа болон материал бүрдүүлэлтийн талаар мэдээлэл авах;

Магадлан итгэмжлэлд бэлтгэх

- ✓ магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу өөрийн үнэлгээ хийх;
- ✓ бэлтгэл ажилд арга зүйн зөвлөгөө авах, шалгуур үзүүлэлтээр үнэлэх аргачлалын сургалтад хамрагдах;
- ✓ магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын болон шинжээчдийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх.

Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах

3.2.8. бэлтгэл ажлыг хангасан байгууллага нь журмын материалыг бүрдүүлж магадлан итгэмжлэх байгууллагад албан ёсоор хүсэлтээ ирүүлнэ.

3.2.9. магадлан итгэмжлэгдсэн байгууллага батламжийн хүчинтэй хугацаа дуусахаас 60 өдрийн өмнө дахин магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргана.

4.1. Бүрдүүлэх материал

1. Магадлан итгэмжлэлд хамрагдах тухай албан хүсэлт;
2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
3. Хугацаа дуусаж байгаа магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар;
4. Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн өөрийн үнэлгээний тайлан;
5. Тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийг (чанар сайжруулах төлөвлөгөө) хэрэгжүүлсэн тайлан;
6. Сүүлийн 2 жилийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд;
7. Бэлтгэл ажлын болон шинжээчдийн өгсөн зөвлөмжийн биелэлт;
8. Магадлан итгэмжлүүлэх үйлчилгээний төлбөр төлсөн баримт.
- 9.

4.2. анх удаа магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж байгаа байгууллага 3-аас бусад материалыг бүрдүүлэх.

Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

- ✓ ЭМБ-ын материалд дүн шинжилгээ хийж, шаардлага хангасан бол 3-5 хүний бүрэлдэхүүнтэй шинжээчдийн баг томилж ажиллуулна.
- ✓ Шинжээчдийн баг үнэлгээний нэгдсэн дүгнэлт гаргаж, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан тухайн байгууллага, хамт олонд танилцуулж зөвлөмж өгнө.
- ✓ Шинжээчдийн багийн ахлагч нь үнэлгээ дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан шинжээчдийн багийн нэгдсэн дүгнэлтийг магадлан итгэмжлэх байгууллагад ирүүлнэ.
- ✓ Шинжээчдийн багийн нэгдсэн дүгнэлтийг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

Магадлан итгэмжлэлийн үнэлгээ

✓ Эрүүл мэндийн байгууллагад ажиллах шинжээчдийн багийн бүрэлдэхүүн:

- эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
- эрүүл ахуй, халдвар хамгаалал
- эмийн чанар, аюулгүй байдал
- эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж

6. Магадлан итгэмжлэл олгох

6.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зөвлөлийн саналыг үндэслэн эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох эсэх шийдвэр гаргана.

6.2. Анх удаа магадлан итгэмжлэгдсэн байгууллагад 1, 2 жилийн хугацаатайгаар, давтан магадлан итгэмжлэгдсэн байгууллагад 1-5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэл олгоно.

6.3. Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт тус бүрийг хангасан байвал 100 хувь гэж үнэлэх ба шалгуурыг хангасан хувийг харгалзан магадлан итгэмжлэл олгоно. Анх удаа магадлан итгэмжлэгдсэн байгууллагад шалгуур үзүүлэлтийг 80-85 хувь хангасан бол 1 жил, 86-аас дээш хувьд 2 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэл олгоно.

Магадлан итгэмжлэл олгох

6.3. Давтан магадлан итгэмжлэгдсэн байгууллагад шалгуур үзүүлэлтийг 85-86,9 хувь хангасан бол 1 жил, 87-88,9 хувьд 2 жил, 89-90,9 хувьд 3 жил, 91-95,9 хувьд 4 жил, 96-аас дээш хувьд 5 жилийн хугацаатайгаар тус тус олгоно.

Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа

6.4. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага нь магадлан итгэмжлэх шийдвэр гарсан өдрөөс хойш 30 өдрийн дотор шинжээчдийн өгсөн зөвлөмжийг тусгасан, чанарын тасралтгүй байдлыг хангах “Тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн үлгэрчилсэн загварыг магадлан итгэмжлэх байгууллага батална.

6.5. Эрүүл мэндийн байгууллага нь магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа дуусаад 1 ба түүнээс дээш жилийн дараа хүсэлтээ гаргах, тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлээгүй бол анх удаа магадлан итгэмжлэгдсэнээр үнэлэгдэнэ.

7. Магадлан итгэмжлэлийг хүчингүй болгох

магадлан итгэмжлэлийг дор дурдсан нөхцөлд хүчингүй болгоно:

1. магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний технологи, эрүүл ахуйн нөхцөл, халдвараас сэргийлэх дэглэм, өвчтөний аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горим зөрчигдсөний улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон болох нь тогтоогдсон;
2. магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан;
3. магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний шатлал, чиглэл, тусгай зөвшөөрөл өөрчлөгдсөн эсхүл татан буугдсан, 6 сараас илүү хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоосон.

8.Маргааныг шийдвэрлэх

1.Эрүүл мэндийн байгууллага нь шинжээчдийн багийн өгсөн дүгнэлттэй санал нийлэхгүй бол магадлан итгэмжлэх байгууллагад хүсэлт гаргаж шинжээчдийн хоёрдахь багийг томилуулж болно. Энэхүү хоёрдахь багийн дүгнэлт нь магадлан итгэмжлэх байгууллагын эцсийн шийдвэрийн үндэслэл болно.

2. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны талаар гарсан маргааныг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

3.Эрүүл мэндийн байгууллага нь зөвлөлийн гаргасан саналыг хүлээн зөвшөөрөхгүй бол холбогдох хууль тогтоомжид заасан дагуу гомдол гаргаж болно.

4. Орон тооны бус шинжээч, шинжээчдийн баг нь гэрээнд өөрөөр заагаагүй бол буруу дүгнэлт гаргаснаас учирсан хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцана.

ЭМС-ын 2016 оны А/118 тоот тушаалын хавсралт

Шинжээчид тавигдах шаардлага

- Тухайн мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан;
- Анагаах ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, мэргэшлийн зэрэг, эсхүл эрдмийн цолтой;
- Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах, баримт бичиг боловсруулах чадвар, дадлага туршлагатай;
- Эмнэлгийн удирдлага, тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын чиглэлээр гадаад, дотоодод урт, богино хугацааны сургалтад хамрагдаж байсан, судалгаа шинжилгээний ажил хийж байсан туршлагатай;
- Тасаг, нэгжийн эрхлэгчээс дээш удирдах албан тушаал эрхэлдэг эсвэл удирдаж байсан туршлагатай;
- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага (эмнэлэг, эм хангамжийн байгууллага)-д удирдах албан тушаал эрхэлдэггүй;
- Ёс зүй, харилцаа, хандлагын зөрчил гаргаж байгаагүй;
- Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй;

Магадлан итгэмжлэлийн шинжээч

ЭМЯ-ны ТНБД-ын 2014.05.30–ны өдрийн 155 тоот тушаал:

✓ Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн 62 шинжээч ажиллахаар шийдвэрлэсэн.

ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ

- ✓ Эрүүл мэндийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль батлагдсан
- ✓ Эрүүл мэндийн сайдын 2017.01.20-ны өдрийн “Хууль дагаж гарах стандарт, дүрэм, журам, бусад шийдвэрийн тухай” А/31 дугаар тушаал
- ✓ Эрүүл мэндийн сайдын 2016 оны 12.26-ны өдрийн “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” 203 дугаар тушаал
- ✓ ЭМХТ-д Чанар, магадлан итгэмжлэлийн алба шинээр зохион байгуулагдаж, зарим чиг үүргийг хэрэгжүүлэх болсон

ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ

- ЭМХТ-ийн ЧМИА-ны үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам”
- Магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг
- Эрүүл мэндийн байгууллагыг магадлан шинжлэх шалгуур үзүүлэлт
- Магадлан итгэмжлэлийн шинжээчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ

- ✓ Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн боловсруулах, батлуулах
- ✓ Аймаг, нийслэлийн ЭМГ-ын оролцоог нэмэгдүүлэх
- ✓ Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, чадавхжуулах
- ✓ Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн сургалтын хөтөлбөр /Сургалтын модуль/ боловсруулах, хэрэгжүүлэх
- ✓ Шинжээчдийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт боловсруулах
- ✓ ЭМБ-уудаас судалгаа авах
- ✓ Магадлан итгэмжлэлийн тасралтгүй сургалтын хөтөлбөр боловсруулах /магадлан итгэмжлэлийн өмнөх, дараах сургалт/
- ✓ Шалгуур үзүүлэлтийг боловсруулах, батлуулах:
 - чанар, гүйцэтгэлтэй уялдуулах
 - чанарын ахисан түвшиний үзүүлэлт /тусламж үйлчилгээний төрлөөр/
 - босго оноо тогтоох /бүлэг бүрээр/

ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ

Дараах бүтэцтэй ажиллах:

- Магадлан итгэмжлэх асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий магадлан итгэмжлэх зөвлөл;
- Өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын алба;
- Орон нутагт үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэг бүхий аймаг, нийслэлийн салбар зөвлөл;
- Магадлан шинжлэх үнэлгээг хийх орон тооны бус магадлан итгэмжлэлийн шинжээч;

ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ

Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны үе шат

- Магадлан итгэмжлэлийн өмнөх үе шат /7/
- Магадлан шинжлэх үнэлгээ хийж, магадлан итгэмжлэл олгох үе шат /5/
- Магадлан итгэмжлэлийн дараах үе шат /8/

Анхаарлаа хандуулсанд баярлалаа

www.moh.gov.mn - вэб хуудас – төрийн үйлчилгээ-
Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл
булан

www.hdc.gov.mn-Эрүүл мэндийн хөгжлийн төв